

Газар эзэмших эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 29 дүгээр зүйлийн 29.1, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус дүүргийн нутаг дэвсгэрт газар дээрээ хашаа, байшин барин суурьшаад олон жил болсон боловч одоо болтол газар эзэмших гэрчилгээгээ аваагүй, шинээр газар эзэмших хүсэлт ирүүлсэн 25 /хорин тав/ иргэний газар эзэмших эрхийг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Газар эзэмших эрх нь баталгаажигдсан иргэдтэй газар эзэмших гэрээг зохих журмын дагуу байгуулж, гэрчилгээ олгон хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Газар зохион байгуулалтын алба /Ж.Мөнх-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ